

**Эрдмийн зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн
хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулав.**

МАГИСТР,ДОКТОР (Ph.D)-ЫН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 тоот тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ыг үндэслэн Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль (цаашид ХИС гэнэ)-ийн магистр, докторын сургалтыг зохион байгуулж явуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Магистр, докторын боловсролын агуулга нь шинжлэх ухаан, технологи, нийгэм хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ үйлчилгээний салбарт олон улсын стандартын өндөр төвшинд ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, дадал судалгааны арга зүйг эзэмшүүлэхэд чиглэнэ.

1.3. Магистрын сургалтын гол зорилго нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа хийж буй бакалаврыг элсүүлэн судалгааны арга зүй эзэмшүүлж магистрын зэрэг олгох түвшинд бэлтгэхэд оршино.

1.4. Докторын сургалтын гол зорилго нь магистрын зэрэгтэй, мэргэжлийн дагуу амжилттай ажиллаж сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр тодорхой бүтээл туурвисан, онолын өндөр мэдлэг, чадвартай хүмүүсийг элсүүлэн ахисан түвшний сургалтанд хамруулж шинжлэх ухааны аль нэг салбарын тодорхой асуудлын хүрээнд (нэг сэдэвт) судалгааны ажил хийлгэж, шинжлэх ухаан, технологийн салбарт бодитой хувь нэмэр оруулах судлаач болгон төлөвшүүлэхэд оршино.

1.5. Магистр, докторын сургалтын журмыг ХИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, сургуулийн захирал батлана.

Хоёр. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. ХИС-ийн салбар сургууль, мэргэжлийн тэнхим нь магистр, докторын сургалтын үйл ажиллагааг бие даан эрхэлж, үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн шалгалт болон магистр, докторын ажлын хамгаалалтыг зохион байгуулах, холбогдох мэдээллийг ХИС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулах үүрэгтэй.

2.2. Магистр, докторын ажлыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх үйл ажиллагааг захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

2.3. Магистр, докторын мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, үр дүнг тооцох ажлыг ХИС-ийн хөтөлбөрийн хороо хариуцна.

2.4. Сургалтын хөтөлбөрийг дүүргэж сургуулиас тогтоосон голч дүнгийн шаардлага хангасан, магистр, докторын ажлаа амжилттай хамгаалан, тухайн ажлаа хянан засварлаж, эцэслэн холбогдох этгээдэд хүлээлгэн өгсөн болон сургуулийн бусад шаардлагыг хангасан магистрант, докторантад захирлын тушаалаар магистр, докторын зэрэг олгохоор шийдвэрлэнэ.

2.5. Тэнхим нь магистр, докторын хөтөлбөр хариуцсан зөвлөх багштай байна.

Гурав. МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТ

А. Ерөнхий зүйл

- 3.1. ХИС-ийн салбар сургууль, мэргэжлийн тэнхим нь магистр, докторын сургалтыг хариуцан, сургалтын зохион байгуулалт, чанарт хяналт тавина.
- 3.2. Магистр, докторын сургалтыг батлагдсан мэргэжлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу явуулна. Сургалтын төлөвлөгөөг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн их сургуулийн захирал батална.
- 3.3. Сургалтын хугацаа суралцах хэлбэр нь Дээд боловсролын тухай хуулийн 10-р зүйлд заасан хүрээнд хэрэгжинэ.
- 3.4. Сургалтын хичээлийн жил нь хоёр улиралтай, улирал тус бүр нь хичээлийн 10 долоо хоног, шалгалтын 1 долоо хоногтой байна. Хичээлийн жилийн улирал 10-р сарын 01 ба 2-р сарын 01 нээс эхэлнэ. Эчнээ магистрант жилд 1 удаа 45 хоногоор, эчнээ докторант 2 удаа 21 хоногоор цугларч хичээллэнэ. Үүнд: жил бүр магистрантын цугларалт 1-р сарын 5 нээс эхэлнэ. Эчнээ докторантын цугларалт 1-р сарын эхний долоо хоногт, дараагийнх нь 6-р сарын 01 нээс тус тус эхэлнэ.
- 3.5. Магистрант, докторант нар элссэнээс хойш нэг сарын дотор сургалтын гэрээ, сурах төлөвлөгөөгөө зохион баталгаажуулж, тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрөө төлсөн байна.
- 3.6. Магистрант, докторант нь бүлэг бүрдээгүй үед удирдагчтайгаа зөвлөн ганцаарчилсан сургах төлөвлөгөө хийж, салбарын эрхлэгчээр хянуулан ХИС-ийн захирлаар батлуулж, мөрдөж болно. Төлөвлөгөөндөө ерөнхий болон мэргэжлийн хичээлүүдийг судлах, диссертацийн сэдвийн чиглэлийг тогтоох, судалгааны семинарт оролцох, сэдэвтэйгээ холбоотой судалгааны ажил хийх талаар улирал бүрээр тодорхой тусгана.
- 3.7. Сургалтын төлөвлөгөөний агуулгыг бүрэн биелүүлж бүх шалгалтуудаа С (голч оноо 70)-ээс доошгүй үнэлгээ авсан магистрант дипломын ажил, мэргэжлийн бүх шалгалтанд В (голч оноо 80)-ээс доошгүй үнэлгээ авсан докторант диссертаци бичиж хамгаалах эрхтэй байна.
- 3.8. Үнэлгээ нь зохих хэмжээнд хүрээгүй магистрант, докторант 2-оос илүүгүй шалгалтаа нэг удаа дахин өгч болно. Шалгалт өгөх зарчим нь өмнөхийн адил байна.
- 3.9. Сонгон суралцах хичээлийг бие даан судалж программын агуулгын зарим хэсгийг удирдагчийнхаа семинарт илтгэх, хэсэг бүлгээр хувааж шалгалт өгөх хэлбэрээр кредитээ тооцуулахыг зөвшөөрнө.
- 3.10. Магадлан итгэмжлэгдсэн бусад их сургуулиас магистрант 4 кредит, докторант 6 кредит цуглуулж болно. Энэ талаар суралцагчийн сурах төлөвлөгөөг анх батлахад тусгана.
- 3.11. Докторант, магистрант нь суралцах хугацаандаа сургуулийн дотоод журмын хүрээнд ХИС-ийн номын сан, компьютерийн болон эрдэмшинжилгээний лаборатори, интернет төвийг ашиглана.

Б. Магистрын сургалт

- 3.12. Бакалаврын түвшний агуулга дээр нэмж 30-аас доошгүй кредитийг магистрын төвшний сургалтын агуулгаар судлуулсан байна.
- 3.13. Магистрын сургалт өдөр, эчнээ, эрчимт; докторын сургалт өдөр, эчнээ, экстернат хэлбэртэй байна.
- 3.14. Магистрын сургалт нь судалгаа шинжилгээний болон мэргэжлийн чиглэлээр ахисан төвшинд мэргэшүүлэх гэсэн хоёр чиглэлтэй байна.
- 3.15. Магистрын сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн онцлогуудыг агуулах бөгөөд БСШУ-ны сайдын А/370 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын 2-р зүйлийг баримтлан боловсруулагдсан байна.
- 3.16. Магистрант нийт судлах багц цагийн 20 багц цагийг судалсны дараа гадаад хэлний шалгалт өгнө.
- 3.17. Магистрант нь магистрын ажил бичихгүйгээр мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлээс 10 багц цаг сонгон судалж, нэгдсэн шалгалт өгч болно. Энэ тохиолдолд нэгдсэн шалгалтад багц цаг тооцохгүй.
- 3.18. Магистрын сургалтанд суралцах хугацаандаа өөрийн судалгааны чиглэлээр ШУА хүлээн зөвшөөрсөн эрдэм шинжилгээний сэтгүүл, бусад хэвлэлд 2-оос доошгүй эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн байна.
- 3.19. Магистрын ажил бичээгүй төгсөгчдийн хөтөлбөр дүүргэснийг баталгаажуулах нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалтыг хөтөлбөрийг хариуцсан нэгж зохион байгуулах бөгөөд шалгалтын журмыг ХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 3.20. Магистрант нь бие даасан судалгааны ажил гүйцэтгэн магистрын ажил бичиж, “Магистрын ажил хамгаалуулах зөвлөл”- д хамгаална.

В. Докторын сургалт

- 3.21. Докторын өдөр ба эчнээ сургалт нь өмнөх төвшний кредит дээр нэмж судлах 60-аас доошгүй кредит цагийн докторын төвшний сургалтад хамаарах сургалт, судалгааны ажлаас тогтоно. Харин экстернат хэлбэрээр суралцагчид нь хөтөлбөрийн агуулгыг бие даан судалж, шалгалтаа өгсөн нөхцөлд докторын зэрэг горилох бүтээлээ хамгаалах боломжтой болно.
- 3.22. Докторын сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн онцлогуудыг агуулах бөгөөд БСШУ-ны сайдын А/370 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын 2-р зүйлийг баримтлан боловсруулагдсан байна.
- 3.23. Докторын сургалтанд суралцах хугацаандаа өөрийн судалгааны чиглэлээр ШУА хүлээн зөвшөөрсөн эрдэм шинжилгээний сэтгүүл, бусад хэвлэлд 3–аас доошгүй эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн байна.
- Тайлбар: Сонинд бичсэн өгүүллийг эрдэм шинжилгээний бүтээлд тооцохгүй. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний бүтээлээ нийтлүүлэхэд хүлээн зөвшөөрөх сэтгүүлийн жагсаалтыг сургуулиас гаргасан байна.
- 3.24. Экстернат хэлбэрээр суралцаж буй докторантын сонгон суралцах хичээлийн 18, эчнээ докторантын 6 кредитийг түүний хэвлэн нийтлүүлсэн бүтээлүүдээр орлуулан үнэлэх зарчим баримтална. Эдгээр бүтээлд:
- А) Сэдэвтэй холбоотой эрдэм шинжилгээний өгүүлэл

Б) ЕБДС-ийн сурах бичиг

В) Их дээд сургуулийн сурах бичиг, гарын авлага

Г) монографи, ном

3.25. Экстернат докторантын бүтээл нь 18 кредитийг төлөөлөхөөр бол үлдсэн кредитийг сонгон суралцах хөтөлбөрөөр нэмж тооцуулна.

3.26. Докторант сургалтын хэлбэрээс үл хамааран их сургуулийн сургалтын ажилд оролцох, хичээл заах, судалгааны төсөлд ажиллахыг дэмжинэ.

3.27. Хичээлийн жилийн сургалт судалгааны ажлын төлөвлөгөө бүрэн биелүүлсэн докторантыг салбарын саналыг үндэслэн ХИС-ийн захирлын захирамжаар дараах шатны сургалтанд дэвшүүлнэ. Дараах шатны сургалтанд дэвшүүлэхэд докторантын сэдвийн реферат хамгаалсан байдал, семинарт оролцсон байдал, сонгон суралцах хичээлээр бичсэн рефератуудын талаархи удирдагчийн үнэлгээ болон судалгааны ажлын үр дүн, идэвхийг голлон харгалзана. Сурах төлөвлөгөөгөө биелүүлээгүй докторантыг давтан сургана.

3.28. Докторант сургалттай холбоотой бүх кредитээ 4 жилд цуглуулсан боловч судалгааны ажлын 12 кредитээ биелүүлж амжаагүй бол түүнд ХИС-ийн докторын үндсэн сургалт дуусгасан тухай магадлагаа олгоно. Докторантын сургалтын кредит уг хичээлийг үзэж шалгалт өгсөн өдрөөс хойш 5 жил хүчинтэй ба энэ хугацаанд докторант эрдэм шинжилгээний кредитээ гүйцээн, диссертациа бичиж докторын зэрэг хамгаалахыг зөвшөөрнө.

3.29. Докторант докторын ажлаа эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалтгалт өгсөн байна.

3.30. Докторант нь бие даан гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнг эмхтгэн докторын ажил /диссертаци/ бичиж, “Докторын ажил хамгаалуулах зөвлөл”-д хамгаална.

Дөрөв. МАГИСТР, ДОКТОРЫН АЖЛЫН УДИРДАГЧ, БАГШ

- 4.1. Магистрын сургалтын багш нь магистраас доошгүй зэрэгтэй, докторын сургалтын багш тухайн чиглэлээр боловсролын (Ph,D)-ын доктороос доошгүй зэрэгтэй байна.
- 4.2. Магистр, докторын сургалтын лектор багш нарт бүтээлийн чөлөө олгох, тэднийг эрдэм шинжилгээний төсөлд ажиллуулах, мэргэшил дээшлүүлэх зэргээр эрдэм шинжилгээний ажил эрхлэх идэвхи санаачлагыг дэмжинэ.
- 4.3. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар (Ph,D) доктороос доошгүй зэрэгтэй, 5-аас доошгүй жил их, дээд сургуульд багшаар ажилласан, эрдэм шинжилгээний ажлын дадлага туршлагатай багшийг ажиллуулна. Гаднын байгууллагаас удирдагч сонгохоор бол тухайн чиглэлээр магистрантын болон докторантын удирдагчаар ажиллуулахдаа гаднын байгууллагаас нийт багшийн 30 хүртэл хувийг гэрээлэн ажиллуулж болно.
- 4.4. Магистрын ажлын удирдагч нь дэд профессороос доошгүй орон тоон дээр ажилладаг, докторантын удирдагч нь нэг сэдэвт зохиол эсвэл их дээд сургуульд үзэх сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэлийн аль нэгийг бичиж хэвлүүлсэн байна. Хэрэв гадны эрдэмтэн хүнийг удирдагчаар томилох бол энэ болзлыг хангасан байхыг шаардана.
- 4.5. Магистрант, докторантын ажлын удирдагч багш нь тэдний судалгааны ажлын төлөвлөгөөг боловсруулах, судалгааны ажлыг удирдан чиглүүлэх туршилт тавих, задлан шинжлэх,

туршилтын дүн боловсруулах, өгүүлэл бичих, илтгэл тавих зэрэгт зөвлөлгөө өгөх, хяналт тавих үүрэг хүлээнэ.

- 4.6. Нэг багш тухайн хичээлийн жилд 5 хүртэл магистрант, 3 хүртэл докторантын ажлыг удирдахыг зөвшөөрнө.
- 4.7. Магистр, докторын сургалтад багш нарт тухайн хичээлийн онцлог, хөдөлмөр зарцуулалтанд нийцсэн цалин хөлс өгөх, сургалтын цагийн ноогдлын хөнгөлөлт үзүүлэх, судалгаа шинжилгээний ажил эрхлэх идэвхи санаачлагыг бүх талаар дэмжинэ.

Тав. МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛАХ

- 5.1. **А.** Сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, сургалтын төлбөрөө төлсөн магистрантуудын дипломын ажлыг хамгаалуулах тухай захирлын тушаал гаргана.
Б. Сургалтын кредитээ биелүүлсэн боловч дипломын ажлаа хугацаандаа хийж дуусаагүй магистрантын хамгаалах хугацааг 0,5-1 жилээр сунгана. Энэ тохиолдолд шаардлагатай гэж үзвэл судалгааны ажилтай холбогдох нэмэлт зардал төлүүлж болно.
- 5.2. Магистрын зэрэг горилж бичсэн дипломын ажил нь тухайн шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлсэн судалгаа, туршилтыг онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, тодорхой сэдвээр бодит үндэслэл, үр дүнд хүрсэн эрдэм шинжилгээний бүтээлийн түвшинд бичигдсэн байх шаардлагатай.
- 5.3. Магистрын дипломын ажил нь 40-80 хуудас хэмжээтэй, хураангуй нь 0,5 х,х, хэмжээтэй бичигдсэн байна.
- 5.4. Магистрын зэрэг горилсон дипломын ажлыг монгол хэлээр бичих ба хураангуйг англи хэлээр бичнэ. Хамгаалсан магистрын дипломын ажлын нэг хувийг сургуулийн номын сангийн эрдэм шинжилгээний гар бичмэлийн фондод бүртгэн авч нийтэд ашиглуулна.
- 5.5. Магистрын дипломын ажил урьдчилсан хамгаалалтаар дамжина.
- 5.6. **А.** Урьдчилсан хамгаалалтын дараа магистрын зэрэг хамгаалах тухай зарыг ХИС-ийн хэмжээнд тарааж, дипломын ажлыг салбар болон сургуулийн номын санд өгсөн байна. Зарлал гарснаас хойш хоёр долоо хоногоос багагүй хугацааны дараа жинхэнэ хамгаалалтыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдаанаар хийлгэнэ. Магистрын дипломын ажлын хураангуйг жинхэнэ хамгаалалтаас 7 хоногийн өмнө хурлын гишүүдэд тараасан байна.
Б. Магистрын дипломын ажлыг өргөн шүүн хэлэлцэх зорилгоор хамгаалуулах зөвлөлийн хуралдаан \тусгай шийдвэр гараагүй бол\ нээлттэй байна.
- 5.7. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг салбар сургууль болон тэнхимийн эрдэмтдээс бүрдүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бусад их, дээд сургуулийн эрдэмтдийг урьж оролцуулж болно.
- 5.8. Магистрын зэрэг хамгаалуулах хурлыг докторын хамгаалалтын хуралдааны дэгийг баримтлан явуулна.
- 5.9. Магистрын дипломын ажилд өгөх зөвлөлийн гишүүдийн саналыг нууцаар хурааж, дундаж үнэлгээг гаргана. Санал хураах хуудсанд гишүүн бүр 100 хүртэл оноо тавьж дүгнэх ба ингэхдээ дараах бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн дундаж оноонд үндэслэнэ. Үүнд: онооны дээд хэмжээ дараах байдалтай байна:

1) Агуулга, шинжлэх ухааны түвшин

20 оноо

- | | | |
|---|---------|---------|
| 2) Үр дүн, шинэлэг тал, онол, практикийн ач холбогдол | 20 оноо | |
| 3) Эзэмшилт (илтгэсэн болон асуултанд хариулсан байдал) | 15 оноо | |
| 4) Шүүмжлэгчийн үнэлгээ | | 15 оноо |
| 5) Удирдагчийн үнэлгээ | | 10 оноо |
| 6) Хэл найруулга, эмхэлж цэгцэлсэн байдал | | 10 оноо |
| 7) Судалгааны үр дүнгээ нийлүүлсэн байдал | | 10 оноо |
- 5.10. Тухайн шинжлэх ухааны салбарын онцлогоос хамаарч эдгээр онооны тодорхой харьцааг хамгаалуулах зөвлөлийн гишүүд хэлэлцэж, өөрчлөн тогтоож болно.
- 5.11. Магистрын дипломын ажилд хамгаалуулах зөвлөлийн гишүүдийн өгсөн онооны дундаж 75-аас доошгүй байвал горилогчид магистрын зэрэг олгох тухай шийдвэр гаргана. Хамгаалуулах зөвлөлийн гишүүдийн өгсөн санал дунджаар оноолоход 75-аас доош боловч зөвлөлийн гишүүдийн 3/4 нь хангалттай гэж санал өгсөн бол амжилттай хамгаалсанд тооцно. Энэ хоёр үзүүлэлтээр “ хангалтгүй” үнэлэлт авсан тохиолдолд зэрэг горилогч 2 жилийн дотор дахин нэг удаа хамгаалалтанд орох эрхтэй байна.
- 5.12. Магистрын зэрэг олгох эцсийн шийдвэрийг ХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 5.13. Хамгаалсан магистр дараах материалыг бүрдүүлэн салбарт тушаана. Эдгээр материалыг дипломын хуулбарын хамт сургуулийн архивт хадгална. Үүнд:
1. Дэлгэрэнгүй анкет (1-р маягт)
 2. Сургуулийн хамгаалуулах зөвлөлийн протокол, тогтоол
 3. Удирдагчийн тодорхойлолт
 4. Магистрын дипломын ажлын албан ёсны шүүмж
 5. Нууц санал хураалтын тухай тооллогын комиссийн тогтоол
 6. Ажил байдлын тодорхойлолт
 7. Тэнхим, номын сантай тооцоо хийсэн тойрох хуудас эдгээр болно.

Зургаа. ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛАХ

- 6.1. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл нь БСШУ-ны сайдын 2014 оны 110 дугаар тушаалын II хавсралтаар баталсан “Доктор (Ph.D) -ын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм” -нд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 6.2. Докторант нь албан ёсоор батлагдаж зөвшөөрөгдсөн сургалтын төлөвлөгөөний дагуу докторын төвшний зохих кредит цагийн агуулга бүхий хичээлүүдийг судлан шалгалтуудаа зохих үнэлгээтэй өгсөн, голч дүнгийн босгын болон гадаад хэлний мэдлэгт тавигдаж буй шаардлагыг бүрэн хангасан гадаад дотоодын хэвлэлд зохих тооны бүтээл хэвлүүлсэн байна.
- 6.3. Ажил нь дор дурьдсан үндсэн шаардлагыг хангасан байна:
- а/ Сэдэв нь шинжлэх ухааны үндэслэлтэй, зах заалийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх
 - б/ Шинжлэх ухаан, технологид тодорхой хувь нэмэр оруулж, онол практикийн асуудлыг шийдвэрлэсэн, улс орны эдийн засаг нийгмийг хөгжүүлэхэд чиглэсэн, сургалт, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний ажилд нэвтрүүлэх асуудлыг тусгасан байх

в/ Дэвшүүлсэн шинэ санал, шийдлийг онол, туршилтаар нотолсон, урьд өмнө мэдэгдэж байсан шийдлүүдтэй бүх талаар харьцуулж шинэлэг болон давуу талыг нь нээн харуулсан байх

г/ Ажлын гол агуулга, үр дүн, дүгнэлт, санаа нь судалгааны ном, хэвлэл, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний бусад бүтээлд нийтлэгдсэн байх

- 6.4. Бүтээл 100-150 хуудастай, компьютерээр 12-ын хэмжээтэй үсгийн шрифтээр, 1,5 мөр хоорондын зайтай, хэвлэмэл хуудас (А 4)-ын хэмжээтэй цаасан дээр зүүн талаас 3,5 см, баруун талаас 1,5 см, дээрээс 2,5 см, доороос 3 см-ийн зай авч бичнэ. Ажлын хураангуй (цаашид “хураангуй” гэнэ) нь А5 –ын хэмжээтэй 12-20 хуудастай байна.
- 6.5. Ажлыг монгол хэлээр, хураангуйг англи хэлээр бичнэ. Сэдвийн онцлогоос шалтгаалан хураангуйг өөр гадаад хэлээр бичиж болно.
- 6.6. Докторант нь судалгааны ажлаа гадаадад гүйцэтгэсэн бол ажлыг англи хэлээр, хураангуйг монгол хэлээр бичиж болно.
- 6.7. Хураангуйд уг ажлын үндсэн агуулга, нээсэн, тогтоосон үр дүн, дэвшүүлсэн санаа, дүгнэлтээ товч дурдаж, зохиогчоос онол, практикт оруулсан хувь нэмэр, судалгааны шинэлэг тал, зохиогчийн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтыг тусгасан байвал зохино.
- 6.8. Ажлын эхний хувилбарыг хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч хуралдаанаар хэлэлцүүлэх үндсэн шаардлагыг хангасан эсэх тухай дүгнэлт гарган холбогдох зөвшөөрөл өгнө.
- 6.9. Салбар нь докторантын доор дурдсан материалыг их семинараар хэлэлцэгдсэн ажлын хамт хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Үүнд:
 - Хамгаалалтад нэр дэвшүүлж буй докторантын тодорхойлолт
 - Сургалтын төлөвлөгөөний дагуу судалсан хөтөлбөрүүд, үнэлгээ
 - Докторантын голч дүн
 - Ажлын талаар их семинараас гарсан дүгнэлт
 - Докторантын бүтээлийн жагсаалт
 - Хамгаалалтанд шаардлагатай бусад материал
- 6.10. Хамгаалалтыг урьдчилсан ба жинхэнэ гэсэн 2 үе шаттайгаар зохион байгуулна.
- 6.11. Урьдчилсан хамгаалалтаас албан ёсны хоёр шүүмжлэгч, шүүмжлэгч нэг байгууллагыг томилж докторантад ажлынхаа хураангуйг хэвлүүлэх зөвшөөрөл олгож, жинхэнэ хамгаалалтын товыг тогтооно.
- 6.12. Докторант нь урьдчилсан хамгаалалтын үед гарсан санал шүүмжлэлээс ажилдаа тусгаж, шаардлагатай засвар хийсний дараа зөвлөлийн даргад танилцуулан, зөвшөөрөл авч жинхэнэ хамгалалтад орно.
- 6.13. Жинхэнэ хамгаалалтыг урьдчилсан хамгаалалт хийснээс 30–аас доошгүй хоногийн дараа хийнэ.
- 6.14. Жинхэнэ хамгаалалтын зарыг хамгаалалт болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө өдөр тутмын сонин хэвлэлээр зарлана.
- 6.15. Жинхэнэ хамгаалалтын зар нийтлэгдсэн өдрөөс хойш бүтээл, түүний хураангуйг Улсын төв номын сан, Мэдээллийн технологийн үндэсний парк, сургуулийн номын санд албан ёсоор өгч, олны хүртээл болгоно.

- 6.16. Урьдчилсан ба жинхэнэ хамгаалалтыг хуралдааны дэгийг баримтлан нээлттэй зохион байгуулах ба шинэ бүтээлийн эрх хамгаалах, гадаад дотоодод патентлах, улсын нууц хадгалахтай холбоотой онцгой тохиолдолд бүтээлийг хаалттай хэлэлцэж болно.
- 6.17. Зөвлөлийн нэг удаагийн хуралдаанаар гурваас илүүгүй ажлыг хэлэлцэнэ. Зөвлөлийн хуралдааныг доор дурьдсан дарааллаар зохион байгуулна. Үүнд:
1. Докторантын талаар зөвлөлийн нарийн бичгийн дарга танилцуулна
 2. Докторантын илтгэл (20 – 30 минут)
 3. Шүүмжлэгчдийн санал, дүгнэлт (урьдчилсан хамгаалалтад хамаарахгүй)
 4. Зөвлөлийн гишүүдийн асуулт, санал, дүгнэлт
 5. Нээлттэй хуралдаанд оролцогчдын асуулт, санал, дүгнэлт
 6. Докторант асуултад хариулж, санал, дүгнэлтийн талаар үг хэлнэ
 7. Шүүмжлэгчдийн дүгнэлт
 8. Удирдагчийн тодорхойлолт
 9. Тооллогын комиссийг сонгон батлана
 10. Гишүүдийн санал хураалт
 11. Тооллогын комисс санал хураалтын дүнг гаргаж зөвлөлийн дарга сонгоно
 12. Тооллогын дүнг үндэслэн зөвлөлийн тогтоол гарна
- 6.18. Зөвлөлийн гишүүд докторантын ажилд 100 хүртэл оноо. Үүнд: докторантын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэрт 35 хүртэл оноо, ажлын онол практикийн ач холбогдолд 30 хүртэл, докторантын судалгаа шинжилгээний арга барил эзэмшсэн байдалд 15 хүртэл оноо, ажлын бичилт, докторантын илтгэх семинар, асуултад хариулсан байдалд 20 хүртэл оноо тус тус өгнө. Гишүүний өгсөн нийлбэр оноо 75 ба түүнээс дээш байх тохиолдолд эерэг, 75-аас доош байгаа нөхцөлд эсрэг санал гэж тооцно.
- 6.19. Зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь эерэг санал өгсөн тохиолдолд тухайн докторантыг амжилттай хамгаалсанд тооцно.
- 6.20. Хамгаалуулах зөвлөлийн тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор сургуулийн захирлын тушаалаар докторын зэрэг олгох шийдвэр гарч диплом олгоно.
- 6.21. Хуралдааны протокол, зөвлөлийн тогтоол, докторантын материал зэргийг тухайн салбар, нэгжид 1 жил хадгалсаны дараа сургуулийн архивт шилжүүлнэ.

Долоо. МАГИСТР, ДОКТОРЫН ЭЛСЭЛТ

- 7.1. Элсэлтийг жилд 2 удаа (9-р сарын 01-нээс 20-нд, 01-р сарын 01-нээс 20-ны) зохион байгуулна.
- 7.2. Элсүүлэх мэргэжлийн чиглэл, хүний тоо, сургалтын төлбөрийн хэмжээг элсэлтийн шалгалт эхлэхээс нэг сарын өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.
- 7.3. Бакалаврын зэрэгтэй хүнийг магистрын, магистрын зэрэгтэй хүнийг докторын сургалтанд уралдаант шалгалтаар элсүүлнэ.
- 7.4. Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг 5-аас дээш жил хийсэн туршлагатай эрдэм шинжилгээний зохих бүтээлтэй, докторын диссертацийн ажлын анхны хувилбарыг бэлэн болгож, их семинараас дэмжлэг авсан онолын өндөр мэдлэг, чадвартай хүнийг экстернат хэлбэрээр докторантаар сургаж болно.
- 7.5. Гадаадын иргэд ХИС-д Засгийн газар хоорондын соёлын хэлэлцээр, сургууль хоорондын гэрээ, хувийн гэрээгээр магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр элсч болно. Эдгээр элсэгчид нь Монгол улсад мөрдөж байгаа магистр,

докторын элсэгчдэд тавигдах боловсролын агуулгын түвшин, стандартад дүйх хэмжээний боловсрол эзэмшсэн байвал зохино.

7.6. **А.** Магистрантаар элсэх хүмүүс дараах материалыг бүрдүүлж сургуулийн элсэлтийн комисст ирүүлнэ. Үүнд:

- Өргөдөл
- Биеийн байцаалт \ нэгдүгээр маягтаар\
- Иргэний үнэмлэх
- Өмнөх түвшний дээд боловсрол (бакалавр, магистр)-ын зэргийн дипломууд, тэдгээрийн баталгаажуулсан хуулбар
- Элсэгчийн мэргэжлийн чадварыг үнэлсэн мэргэжлийн эрдэмтний тодорхойлолт
- Холбогдох тэнхимийн санал
- 4 x 3 –ийн хэмжээтэй фото зураг 2 хувь
- Элсэлтийн хураамж тушаасан баримт

Б. Докторантаар элсэхэд дараах материалыг нэмж бүрдүүлнэ. Үүнд:

- Судалгааны ажлын агуулга, чиглэл, зорилгын талаар удирдагч багш нь зөвшөөрсөн танилцуулга
- Бүтээлийн баталгаажуулсан жагсаалт

В. Тус сургуульд суралцах гадаадын иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- Засгийн газар хоорондын гэрээгээр суралцах бол боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан бичиг
- Дэлгэрэнгүй анкет \тусгай маягтаар\
- Эрүүл мэндийн тодорхойлолт
- Паспорт ба паспортын хуулбар
- Өмнөх шатны боловсролын зэргийн үнэмлэх, диплом, тэдгээрийн баталгаажуулсан хуулбар \орчуулгын хамт\
- Элсэлтийн хураамж тушаасан баримт
- 4 x 3 –ийн хэмжээтэй фото зураг 2 хувь

7.7. ХИС-иас өөр сургууль төгссөн хүн магистрант, докторантаар элсэхэд өмнөх (бакалавр, магистрын) түвшинд үзэж судалсан хичээлийн агуулга нь тус их сургуулийн харгалзах чиглэлийн сургалтын агуулгаас зөрөөтэй байвал суралцагч 1-2 улирал бэлтгэл сургалт дамжина. Нэмж судлах хичээлийг удирдагч багш, тэнхим, сургалтын алба хамтран шийдвэрлэх бөгөөд сургалтын төлбөр төлнө.

7.8. Элсэлтийн шалгалт нь урьдчилсан зарлагдсан мэргэжлийн чиглэлийн дагуу явагдах бөгөөд гадаад хэл, мэргэжлийн шалгалт, ярилцлагаас бүрдэнэ.

7.9. Элсэлтийн шалгалтанд тэнцсэн хүнийг суралцуулах тухай захирлын тушаал гарснаар элссэнд тооцно. Тушаалд сургалтын чиглэл, хэлбэр, мэргэжил, хугацааг тодорхой заасан байна.

Найм. ТӨГСӨЛТ, СУРАЛЦАГЧДЫН ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨН

8.1. Магистрын сургалтаар 24 кредитээ бүрэн биелүүлсэн боловч магистрант дипломын ажлаа хамгаалж чадаагүй бол түүнд магистрын сургалт дүүргэсэн тухай магадлагаа олгоно.

- 8.2. Докторантын сургалттай холбоотой бүх кредитээ 3 – 3,5 жилдээ цуглуулсан боловч судалгааны 12 кредитээ биелүүлж чадаагүй докторантад ХИС-ийн докторын сургалт дүүргэсэн гэрчилгээ олгоно. Докторантын сургалтын кредит 5 жил хүчинтэй ба 5 жилдээ багтаан судалгааны кредитээ нөхөн цуглуулж, диссертаци хамгаалж докторын \ Ph.D\ зэрэг авах эрхтэй байна.
- 8.3. Гадаад, дотоодын өөр сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад суралцаж буй магистрант\ докторант зарим хичээлээр шалгалт өгөхийг хүсч өргөдөл гаргавал, харгалзах тэнхим шалгалт авч болно. Шалгалтын төлбөрийг уг хичээлийн кредитийг харгалзан тогтооно.
- 8.4. ХИС-ийн магистр, докторын сургалтанд элссэн хүмүүст хүндэтгэх шалтгаан гарч суралцах боломжгүй болсон тохиолдолд сургалтаас 1 жилийн чөлөө олгох ба чөлөөг нэг удаа сунгаж болно
- 8.5. Хэрэв элсэлтийн шалгалтанд тэнцсэн элсэгч сургалтын төлбөрөө тухайн хичээлийн жилд төлөх боломжгүй бол ХИС-ийн захирлын захирамжаар 1 удаа 1 жилийн чөлөө олгож дараа жил үргэлжлүүлэн сургаж болно.
- 8.6. Нэг улирлын шалгалтаар 2 хичээлийн шалгалтаа амжилтгүй өгсөн буюу нэг шалгалтанд 3 удаа хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд магистрант \ докторантыг сурлагаар хасна.
- 8.7. Магистрант нь сурах чиглэлээ сургууль дотроо өөрчлөх хүсэлт гаргавал суралцах салбарын эрхлэгчийн зөвшөөрлийг үндэслэн түүний суралцах чиглэлийг ХИС-ийн захирлын тушаалаар өөрчилж болно.
- 8.8. Бусад их сургуульд элссэн магистрант \ докторантыг ХИС-д шилжүүлэн авч сургаж болно.

Ес. МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨР

- 9.1. Магистр, докторын сургалтын төлбөрийн хэмжээг ХИС тогтооно.
- 9.2. Гадаадын иргэдийн сургалтын төлбөрийг тусгайлан тогтооно.
- 9.3. Магистрант, докторант сурлага, сахилгаар хасагдах болон хүсэлтээрээ чөлөөлөгдвөл засгийн газар, захиалагч байгууллагаас гарсан зардлыг буцааж төлөх асуудлыг суралцагч өөрөө хариуцна. Магистрант, докторант дипломын ажил, диссертация хамгаалахдаа амжилтгүй дүн үзүүлсэн, мөн сурлагаар хасагдсан бол сургалтын төлбөрийг буцааж олгохгүй.
- 9.4. Хамгаалалтын ажлаа дахин хийсэн тохиолдолд магистрант хамгаалалттай холбогдох зардлыг өөрөө төлнө.
- 9.5. Докторант тус журмын 8,2 –т заасан нөхцлөөр диссертация хамгаалах бол хамгаалалттай холбоотой төлбөрөө төлнө.
- 9.6. Магистрант, докторант шалгалтын дүнгийн босго хүрээгүй үед дахин шалгалт өгөх бол доор зааснаар сургалтын төлбөрийг өөрөө төлнө. Үүнд:
 - А). Нэг шалгалт өгөх бол шалгалтын комиссийн гишүүдийн шалгалт авсан хөлс (гишүүн бүрт 2 цагаар тооцож) төлнө.
 - Б). Хоёр шалгалт дахин өгөх бол магистрант, докторант 1 кредит цагийн сургалтын төлбөр болон шалгалтын комиссийн гишүүдийн шалгалт авсан хөлс (гишүүн бүрт 2 цагаар тооцож) төлнө. Дахин шалгалтын төлбөрийг ХИС-ийн санхүүд төлсөн баримтыг үндэслэн дахин шалгалт өгөх комисс байгуулж, шалгалт өгөх эрх олгоно.

Арав. НОМЫН САН, МЭДЭЭЛЛИЙН ХАНГАМЖ

10.1. Номын сан нь ахисан төвшний сургалтын чиглэл бүрд хүрэлцэхүйц хэмжээний ном, сурах бичигтэй байхаас гадна мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цувралын сантай байж сургалтыг дэмжих таатай нөхцлийг буй болгоно.

10.2. Номын сангийн нөөцийг тухайн төвшний сургалт, судалгааны ажилд гарч буй хэрэгцээ, шаардлага, төрийн захиргааны төв байгууллага ба тухайн боловсролын байгууллагын стратегийн зорилго, бодлогод гарч буй өөрчлөлтөд нийцүүлэн тухай бүр шинэчилж байна.

10.3. Номын сан нь магистр, докторын сургалтад суралцагчдын тоог харгэлзсан, тэдэнд зориулсан суудал бүхий нээлттэй уншлагын танхим ажиллуулна.

10.4. ХИС нь магистрант, докторантыг интернет ашиглах боломжоор хангана.